

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
БОЛОН ТОКИО ХОТЫН ЗАХИРГАА
ХООРОНДЫН СОЛИЛЦОО, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ТУХАЙ ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

Монгол Улс, Япон Улс хооронд анх 1972 онд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Токио хотын Захиргаа хооронд өнөөг хүртэл бий болгосон хамтын ажиллагаа нь хоёр хотын оршин суугчдад өгөөжтэй байх зорилгоор дараах салбарт хамтран ажиллахаар тохиролцов. Үүнд:

- (1) Хот төлөвлөлт ба байгуулалт
- (2) Байгаль орчин, ногоон хот байгуулалт, тойрог эдийн засаг болон хог хаягдлын менежмент
- (3) Усан хангамж, ариутгах татуургын систем
- (4) Тээвэр
- (5) Спорт, аялал жуулчлал
- (6) Эрүүл мэнд

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс болон Токио хотын Захиргааны Бодлого төлөвлөлт, Олон улсын харилцааны хэлтэс нь энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг ханган ажиллах бөгөөд талууд харилцан тохиролцсон чиглэлээр солилцоо, хамтын ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэхэд тууштай дэмжиж ажиллана.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Токио хотын Захиргаа нь тус харилцан ойлголцлын санамж бичигт тусгагдсан салбарын бодлого хэрэгжүүлэх үүрэг бүхий газарт дэмжлэг үзүүлнэ.

Энэхүү санамж бичгийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр монгол, япон хэлээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Талууд тус бүр харилцан ойлголцлын санамж бичгийн нэг хувийг хадгална.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

ТОКИО ХОТЫН ЗАХИРАГЧ

ХИШГЭЭГИЙН НИЯМБААТАР

ЮРИКО КОИКЕ